



Байнгын хорооны хуралдааны тэмдэглэл
2026 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2026 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАН

2026 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2026 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр Даваа гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-13

1.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2026.08.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/	4-13
--	------

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны ээлжит бус чуулганы
Төсвийн байнгын хорооны 09 дүгээр сарын 14-ний өдөр
/Даваа гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Н.Наранбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 30 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 56.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 13 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: П.Мөнхтулга, Ч.Номин, Д.Пүрэвдаваа, Б.Түвшин;

Эмнэлгийн чөлөөтэй: Д.Батбаяр, Д.Энхтүвшин;

Тасалсан: Х.Болормаа.

Нэг.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2026.08.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд Л.Энх-Амгалан, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Л.Отгонтуяа, А.Энхбат, Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч Э.Анар, мөн банкны Санхүү, зах зээл, валютын газрын захирал П.Мөнхбаяр, Мөнгөний бодлого, судалгааны газрын Макро эдийн засгийн шинжилгээ, судалгааны хэлтсийн захирал Б.Цэнд-Аюуш, Монгол Улсын ерөнхий аудиторов орлогч З.Цэдэнжав, Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Баттуяа, Санхүүгийн аудитын газрын менежер С.Нацагдорж, Гүйцэтгэлийн аудитын газрын менежер М.Наранжаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Дашпүрэв, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, мөн газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүүгийн хэлтсийн дарга Ж.Гэрэлбат, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Төгөлдөр, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Санжаадорж, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, мөн газрын мэргэжилтэн Р.Хангал, Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Л.Ичинноров, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга В.Содномдаржаа, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, мөн хэлтсийн шинжээч Б.Очиртогтох, ахлах мэргэжилтэн Б.Дэнсмаа, Төсвийн орлогын хэлтсийн дарга Г.Гантулга, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага арга зүйн газрын дарга Р.Мягмаржав,

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Отгонцэцэг, “Чингис хаан баялгийн сан нэгдэл” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Б.Даваадалай, мөн компанийн Стратеги, бизнес хөгжлийн газрын дарга Б.Мэндбаяр, Санхүүгийн бодлогын газрын дарга Ц.Зоригтбат, Төслийн удирдлагын газрын дарга Б.Баярдаваа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Ууганцэцэг, С.Төрмөнх нар байлцав.

Төсвийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Д.Жаргалсайхан, Г.Ганбаатар нарын тавьсан асуултад Сангийн сайд З.Мэндсайхан, Боловсролын сайд Л.Энх-Амгалан, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Дашпүрэв, Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч Э.Анар, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Чингис хаан баялгийн сан нэгдэл” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Б.Даваадалай нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг нар үг хэлэв.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 32 минут үргэлжилж, 30 гишүүнээс 23 гишүүн хүрэлцэн ирж, 76.7 хувийн ирцтэйгээр 13 цаг 45 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН

ХОРООНЫ ДАРГА

Н.НАРАНБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ

ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр,
Даваа гараг Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим 13 цаг 13 минут

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Наранбаатар: Төсвийн Байнгын хорооны өнөөдрийн хурлын ирц 30 гишүүнээс 19 гишүүн ирж, 63.3 хувьтай ирц бүрдсэн тул ирцэд орсон гишүүд Сүхбаатар танхимд орж ирнэ үү.

Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны хурлын гишүүдийн олонх хүрэлцэн ирж Байнгын хорооны ирц 66.7 хувьтай бүрдсэн тул Төсвийн Байнгын хорооны 2026 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Ирц дахиад шинэчлэгдчихсэн үү? Ирсэн гишүүдийг нэрсийг уншиж танилцуулъя. Норовын Алтанхуяг, Жигжидийн Батжаргал, Хүрэлбаатарын Булгантуяа, Пүрэвжавын Ганзориг, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан, Пүрэвжавын Сайнзориг, Баттогтохын Чойжилсүрэн, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Жамбын Батсуурь, Жамбалын Ганбаатар, Цэрэнпилийн Даваасүрэн, Баатаржавын Мөнхсоёл, Ганзоригийн Тэмүүлэн, Доржсүрэнгийн Үүрийнтуяа, Ринчендоржийн Батболд, Жадамбын Баясгалан, Гомбын Ганбаатар, Дамдинсүрэнгийн Жаргалсайхан, Нанзадын Наранбаатар, Даваагийн Цогтбаатар гээд ирц 66.7 хувьтай байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлэг. Засгийн газар 2026 оны 8 сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу. Саналтай гишүүн байхгүй бол хэлэлцэх асуудалдаа оръёо.

Нэг.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн

2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Загджавын Мэндсайхан Сангийн сайд, Ланганы Отгонтуяа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Амаржаргалын Энхбат Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Энхболдын Анар Монголбанкны тэргүүн дэд ерөнхийлөгч, Занданбазарын Цэдэнжав Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Дэлгэрийн Энхболд Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Буяндэлгэрийн Баттуяа Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Сүхбаатарын Нацагдорж Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитын менежер, Машдэлгэрийн Наранжаргал Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын аудитын менежер, Маамбын Үнэнбат Монголбанкны Хуулийн газрын захирал, Болд-Эрдэнийн Цэнд-Аюуш Монголбанкны Мөнгөний бодлого, судалгааны газрын Макро эдийн засгийн шинжилгээ, судалгааны хэлтсийн захирал, Батхишигийн Мөнх-Эрдэнэ Эдийн засаг хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Батжаргалын Төгөлдөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Чойгүнсэнгийн Чимидсүрэн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Жамьяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Лувсанвандангийн Ичинноров Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Батжаргалын Цогтнаран Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ганбаатарын Жаргалсайхан Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Жаргалсайханы Гэрэлбат Эдийн засаг, хөгжлийн яамны ТЗУГ-ын Санхүүгийн хэлтсийн дарга, Ваанчиг-Арслангийн Содномдаржаа Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга, Пүрэвдоржийн Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Галбадрахын Гантулга Сангийн яамны төсвийн орлогын хэлтсийн дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Рэгзэнгийн Мягмаржав Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга, Нэргүйн Цолмон Гаалийн ерөнхий газрын Татвар, орлогын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Баатарын Болд Татварын ерөнхий газрын Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга, Батнямын Отгонцэцэг НЗДТГ-ын хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Батсуурийн Даваадалай “Чингис хаан баялгийн сан” нэгдэл ХХК-ийн гүйцэтгэх захирал, Болдсайханы Мэндбаяр “Чингис хаан баялгийн сан” ХХК-ийн Стратеги, бизнес хөгжлийн газрын дарга, Цэвээнжавын Зоригт-Од “Чингис хаан баялгийн сан” нэгдэл ХХК-ийн Санхүүгийн бодлогын газрын дарга, Баярсайханы Баярдаваа “Чингис Хаан баялгийн сан” нэгдэл ХХК-ийн Төслийн удирдлагын газрын дарга, Төмөрийн Билгээ ЭТТ ХК-ийн Захиргаа удирдлагын газрын дарга, Ганболдын Бадрах ЭТТ ХК-ийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн далдугаар зүйлийн 70.3-д Байнгын хороо эрхлэх асуудлын хүрээнд төсвийн төслийн

хэлэлцүүлэг хийсэн талаар танилцуулга боловсруулж Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын байнгын хороод 2026 оны 9 дүгээр сарын 8, 9, 10-ны өдрүүдийн хуралдаанаараа Монгол Улсын 2026 оны төсвийн тодотголын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулж танилцуулгаа Төсвийн байнгын хороонд ирүүлснийг та бүхэнд тараасан болно оо.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70.2-т Байнгын хорооны гишүүд тухайн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хууль санаачлагч Монгол Улсын ерөнхий аудитор, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, үг хэлнэ гэж заасны дагуу Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн талаар асуулт асуух гишүүн байна уу? Гишүүд нэрсээ өгье. Лувсанжамц гишүүнээр тасаллаа. Асуулт асууя Лувсанжамц гишүүн.

Г.Лувсанжамц: Өдрийн мэнд хүргэе ээ.

Төсвийн тодотголын төслийг ерөнхийд нь дэмжиж байгаа. Гэхдээ 2, 3 зүйл дээр асуулт асуух хэрэгтэй байна аа.

Нийтдээ 1.4 их наяд төгрөгийн өөрчлөлт гарч байгаа. Бид нарын баталсан өнгөрсөн намар баталсан төсвөөс өөрчлөлт орж байгаа. Үүн дээр үнэ тогтворжуулахаар 150 тэрбум, эрчим хүчний засвар, татаас 200 тэрбум, гэрт ойр сургууль 50 тэрбум гэсэн агуулга орж ирсэн. Тэгээд төсвийн 1 дүгээр хавсралт буюу шалгуур үзүүлэлтийн хавсралт D _parliament.mn дээр тавьсан агуулгаас олж харсангүй ээ. Тэгээд Сангийн сайдаас 1 дүгээрт асууя.

1.4 их наяд төгрөгийн өөрчлөлт гараад байхад хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт өөрчлөгдөхгүй юу? Яагаад өөрчлөгдөхгүй байгаа юм гэдэг чинь нэг талдаа бид нар үр дүнгээ зорьж төсөвлөх биш төсөвтөө тааруулаад ажиллаад байна гээд, байгаа мөнгөндөө тааруулж ажиллаж байгаа гэсэн ийм дараалал нь буруу болчихоод байгаа юм болов уу гэж бодож байна л даа. Тэгэхлээр сая хэлсэн татаасууд байгаа. Энэ татаасууд дээр 1 дүгээрт Эдийн засаг, хөгжлийн яамнаас төсвийн шалгуур үзүүлэлт дээр голч орлогын 50 хувиас доогуур амьжиргаатай хүн амын нийт хүн амд эзлэх хувийг багасгаж явна гэсэн тийм зорилго тавьсан байгаа. Тэгээд яг энэ багш эмч нар болон төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг нэмснээрээ энэ шалгуур үзүүлэлт яаж ахих вэ? Эхний асуулт.

Хоёр дахь нь 4.1.4 дээр өрхийн бодит орлогын өсөлт байна. Энэ 5 хувьтайгаар авч явна гэж байгаа. Энэ яаж өөрчлөгдөж байгаа вэ? Баялгийн сангийн хуримтлагдсан үлдэгдэл болон хөгжлийн сангийн хуримтлал энэ дээр ямар өөрчлөлтүүд орж байгаа вэ гэсэн асуулт байна.

Боловсролын яамнаас энд хүн байхгүй байх тиймээ. Нэгдсэн чуулган дээр асууя гэж бодож байгаа. Энэ дээр Боловсролын яамныхан бэлдэж байвал зүгээр байна.

Гэрт ойр сургууль гэж хөтөлбөр хэрэгжүүлэх гэж байгаа бол шалгуур үзүүлэлтийн 1.2.1 дээр байгаа төрийн өмчийн ЕБС-ийн бүлэг дүүргэлт 35-аас доош сурагчтай байгаа гэж нийт тийм тоог хувийг нь гаргана гэсэн байгаа. 50 тэрбум төгрөг зараад ангидаа 35-уулаа сууж байгаа бүлгийн тоо хэд болж цөөрч байгаа юм

бэ. Ихсэж байгаа юм бэ? Энэ өөрчлөлтүүдийг бид нар шалгуур үзүүлэлтээ харж л ярих ёстой. Энэ мэдээллүүдийг авмаар байна.

Инфляцтай уялдуулаад хариуцаж байгаа нь Эдийн засгийн хөгжлийн яам учраас асууя.

Инфляцын түвшин дотор нийлүүлэлтийн шалтгаантай инфляц, хүнсний барааны үнийн өсөлт гэсэн 2 шалгуур үзүүлэлт Эдийн засаг, хөгжлийн яаман дээр байдаг. 5 хувь байлгана. 2026 оны хувьд 7 хувь байлгана гэсэн. Одоогоор бид нар 13 хувь, өнгөрсөн сарынхаа 12.5 хувь байгаа хүнсний барааны үнийн өсөлтийг 6.5 хувь дээр барина гэсэн. Нийтдээ бид нар энэ 150 тэрбум төгрөгийг татаас ороод үнэ тогтворжуулна гэж гэж байгаа бол энэ инфляц маань яаж өөрчлөгдөх вэ гэдэг төсөөллөө хариулна уу.

Н.Наранбаатар: Гишүүний асуултад хариулъя. Сангийн сайд Мэндсайхан сайд хариулъя. 5 дугаар микрофон.

3.Мэндсайхан: Лувсанжамц гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр мэдээж төсвийн ерөнхийлөн захирагч дээр багцад өөрчлөлт орж зардлын ангилал өөрчлөгдөж байгаа учраас мэдээж хүрэх үр дүн дээр өөрчлөлт гарах ёстой. Төсвийн тодотголын ерөнхий 2 зорилго бол 1 дүгээрт иргэдийн инфляцад идэгдээд байгаа иргэдийнхээ орлогыг хамгаалах нөгөө талдаа тэр нийлүүлэлтүүдийг дэмжээд байгаа инфляцын өдөөлтийг бууруулах зорилгоор нөөц бүрдүүлье гэдэг энэ 2 үндсэн бодлогын хүрээнд орж ирж байгаа. Энэ хүрээндээ мэдээж гол инфляцын бүтцээ аваад харах юм бол энэ инфляцын бүтцийн 50 хувь нь манай дотоодын хүнс, ногоо, гурил байгаа. Нөгөө талдаа импортоор орж байгаа бензин, түлшний үнэ байгаа юм.

Тэгэхээр энэ чиглэл дээр нь бид нар нөөц бүрдүүлье. Инфляцыг тодорхой хэмжээтэй нийлүүлэлтийн талаас өдөөж байгаа өдөөлтийг тэнд тогтворжуулах чиглэлээр бодлого оруулж ирж байгаа. Мэдээж цалин хөлсний хувьд бол өмнөх 2 салбарыг ингээд зөрөөтэй байдлаар нэмэгдсэнээс болоод бусад салбарууд маань асуудал үүссэн. Энэ асуудлаа бид нар төсвийн тодотголоороо шийдээд ороод ирье. Төрийн үйлчилгээний албан хаагч болон эрүүл мэндийн салбарын цалинг 11 сарын 1-ээс эхлээд нэмэгдүүлье.

Хамгийн их инфляцын үнийн өсөлтөд нэрвэгдэж байгаа ахмадуудын 450 орчим мянган ахмадуудынхаа орлогыг хамгаалъя гэдэг бодлогыг оруулж ирж байгаа. Үүнтэй уялдаатайгаар мэдээж цаашдаа бид нар юу баримтлах вэ гэхээр Засгийн газар цалин хөлсний энэ их олон салбар хуулиараа зохицуулаад байгаа 33 орчим хуулиар зохицуулж байгаа. Эдгээрийн нэгдсэн цалин хөлсний нэгдсэн бодлогыг боловсруулах шаардлагатай байгаа. Энэ хүрээндээ Аубакир сайд бид 2 саналаа солилцоод ер нь Засгийн газар дээрээ нэгтгэсэн. Одоо ТАЗ-өөс саналаа авах юм бол ойрын хугацаанд энэ цалин хөлсний бодлогын талаар баримтлах хуулийн төслөө Засгийн газар Их Хуралд орж өргөн барина гэсэн ийм төлөвлөгөөтэй байна. Баялгийн сангийн асуудлаар Тулгаа дарга нэмээд хариулчих.

Н.Наранбаатар: 8 дугаар микрофоныг нээе.

С.Тулга: Сангийн яам Тулгаа гишүүний асуултад хариулъя аа.

Үндэсний баялгийн сангийн хувьд хуримтлалын сангийн орлого бол анх батлагдсан хэмжээнд өөрчлөлт ороогүй байгаа. Энэ ирээдүй өв сангийн орлогын хувьд бол АМНАТ-ийн орлого нэмэгдсэнтэй холбогдуулаад нийт хуримтлал 459 тэрбумаар нэмэгдэхээр тооцоолсон байгаа.

Н.Наранбаатар: Өөр хэн хариулах вэ? Нэмж. Эдийн засаг хөгжлийн яам. 8 дугаар микрофон.

Б.Дашпүрэв: Гишүүний асуултад хариулъя аа.

Инфляцын тухайд бол 60 хувь нь нийлүүлэлтийн гаралтай инфляц бүрдүүлж байна. Одоо энэ 2026 оны 8 сарын гүйцэтгэлээр тэгээд бид нарын прогнозоор бол 2027 оны тухайд инфляц ирэх онд нэг 8 орчим хувьтай. Түүнээс нийлүүлэлтийн шалтгаантай инфляц буурч 3.5 нэгж хувь орчим болж буурна гэж төсөөлж байна аа. Нөгөө талдаа 5 орчим нэгж хувь нь бол эрэлтийн шалтгаантай инфляц байна гэж төсөөлж байна аа. Нийлүүлэлтийн шалтгаантай инфляц буурахад бол гол нь мах, төмс, хүнсний ногоо, гурилын инфляцууд дээр арга хэмжээг авч хэрэгжүүлнэ гэсэн асуумжаа авсан байгаа.

Н.Наранбаатар: Жаргалсайхан гишүүн асуулт асууя.

Д.Жаргалсайхан: Өнөөдөр хэдүүлээ ингээд нэг төсвийн тодотгол хийгээд тэгээд энэ тодотгол дээр энэ танилцуулагдаж байгаа материал дотор нэг ийм асуудал байгаа юм. Дутуу үлдээсэн санхүүжилт тодотгож байна гээд. Тэгээд миний хувьд өмнө энэ 2026 оны төсвийн ажлын хэсэгт орж ажиллаж байсан. Тэгээд энд ажиллаж байсан хүмүүс байна. Ажлын хэсгээ ахалж байсан Ганхуяг гишүүн байна.

Тэгэхээр бид нар ажлаа нэг муу хийчихсэн юм шиг байдлаар л ингээд харагдаад байна л даа. Төсвийн яг энэ тод юун дээр бол орж ирж байгаа тэр цалингийн дутуу санхүүжилт гэж яриад байгаа юм. Энэ дутуу санхүүжилт биш шүү дээ. Улсын Их Хурлын чуулганаар бол багш, эмч нарын цалинг гэж ингэж алга цохиочихсон. Яг ингэж хуралдаанаар энэ асуудал шийдэгдсэн. Гэтэл ажилчдын гэдэг үг нэмээд энэ цалингийн санг ингээд ажилчид хуваарилаад явчихсан асуудал байгаа юм. Тэгээд тэрнээс зөрөө гарчхаад тэр алдааг л бид нар өнөөдөр засаж байгаа байхгүй юу. Тэгээд энэн дээр та хэд ямар байдлаар ийм тайлбар бичсэн юм? Энэ алдаагаа хүлээн зөвшөөрч байна уу? Энэ алдаатай холбоотой хэн хариуцлага хүлээж байгаа юм? Ер нь цаашдаа ингээд хуулиа бид нар ингээд зөрчөөд тэгээд зөрчих зөрчихдөө бүүр ингээд төсвөө хүртэл ингээд зөрчдөг ийм байдалд хавтгайрвал яах вэ? Тэгээд Монгол Улсынх нь Ерөнхий сайд хүртэл хэлж байна шүү дээ. Энэ төсвийг та хэд маань нэг яг хууль дүрмийнхэнд зарцуулаарай гэж бүүр тусгайлан захидаг болох уу? Хууль ийм байдалд хэрэгжих юм уу? Энэ дээр ямар арга хэмжээ авах юм бэ? Энийг цааш нь хэдүүлээ яаж энэ хуулиа хэрэгжүүлдэг болох юм? Тэгээд ийм байдлаар алдаа гаргачхаад араас нь ингээд тэр үед бид нар дутуу баталчихсан шиг байдлаар ингэж оруулж ирж байгаад сэтгэл дундуур байна. Энэ дээр нэг хариулт өгөөч.

Мөн дээрээс нь энэ манай хөдөө орон нутагт бол маш их ард иргэд төрийн байгууллага тэр тусмаа гаднаас энэ орж ирж байгаа энэ хүмүүстэй холбоотой үл ойлголцох ийм асуудлууд маш их болж байна. Жилийн жилд тэрний нэг нь энэ шонхор шувуу барих зөвшөөрөл олгосон асуудал байгаа. Баянхонгор аймгийн

Бууцагаан сумд гэхэд бэлчээрээ хамгаалсан ийм залууг бол хүүгийнх нь нүдэн дээр дайрч амь насыг нь хохироосон асуудал байгаа юм. Тэгээд энэнтэй холбоотой олон иргэд хүсэлт ирүүлж байна аа. Ер нь энэ шонхор шувууг барихад хэдэн төгрөг орж ирдэг юм улсын төсөвт. Ер нь энийг болиулчихвал яасан юм? Жилийн жилд нэг ийм байдлаар ингээд яваад байгаа нь бидний хувьд энэ бид нарт нэмэр болж байгаа юм уу энэ орж байгаа төсөв нь гэсэн ийм 2 асуулт байна.

Ер нь цаашдаа хэдүүлээ энэ төсөв бүрдүүлж байгаа энэ нэгжүүд дээрээ нэг сайн харахгүй бол яг энэ мэтчилэн улсын төсөвт нэг тодорхой дэмжлэг болохгүй тэгээд ард иргэд, энэ төр засгийг хооронд нь ингээд талцуулсан ийм асуудлууд дээр ер нь та хэд маань ямар байр суурьтай ямар байдлаар энэ төсвийн орлого бүрдүүлэх дээр ажиллаж байна вэ? Энэ дээр нэг тодорхой саналууд шийдлүүд гаргаач. Жишээ нь энэ шонхор шувуун дээр гэсэн ийм 2 асуултыг асууя.

Н.Наранбаатар: Сангийн сайд хариулъя. Мэндсайхан сайд.

З.Мэндсайхан: Багш, эмч нарын ажилчдын цалингийн асуудал бол өнгөрсөн жил Засгийн газар Их хуралд төсвөө өргөн барихдаа цалин нэмэгдүүлэхгүй гэдэг байдлаар өргөн барьсан. Их Хурал дээр санал гараад тухайн үед манай Хассуурийн Ганхуяг гишүүн ажлын хэсгийг ахалж байсан төсвийн ажлын хэсгийг. Ингээд багш, эмч нарын цалинг нэмье гэдэг зардлыг нь төсөвт суулгаж өгсөн. Хэлэлцүүлгийн явцад. Ингээд яг батлагдахад зарчмын зөрөөтэй санал гаргаад төсвийн хэлэлцүүлэг дуусаад тогтоолд дагаж гарах тогтоол батлагдахад багш ажиллагсдын болгож тогтоол батлагдсан. Ийм учраас төсвийн эх үүсвэр маань хүрэхээ больсон. Энэнтэй холбоотой зардлыг л бид нар Засгийн газар зардлаа танаж оруулж ирж байгаа. Түүнээс биш юу гэдэг юм багш ажиллагсдын гэж анхнаасаа төсөвлөөд энэ зардлын задаргааг нь хууль дээр төсөв хэлэлцэж байх явцад яригдаагүй, зөвхөн багш, эмч нарын цалин гэдэг асуудлаар тухайн үеийн төсвийн ажлын хэсэг энэ зардлынх нь орон зайг нь төсөвт өргөн барьсан төсөв дотор таналт хийгээд зохицуулалтыг нь хийгээд эх үүсвэрийг нь бүрдүүлээд гаргасан. Тогтоол батлагдахдаа төсвийн хэлэлцүүлэг дууссаны дараа тогтоол батлагдаж гарахад эцэслэн гарахдаа багш ажиллагсад болсон. Энэ чинь хэрэгжилтийн шат дээрээ зардал нь 2 дахин өссөн ийм л асуудал байгаа.

Тэгэхээр энэ асуудлыг бид нар цэгц зардлаа танаад оруулж ирж байна л гэсэн үг.

Өнгөрсөн жилд яах вэ тэр шонхор шувуу ашигласны төлбөрийн орлого бол орон нутгийн төсөвтөө орж байгаа. Зургаа орчим тэрбум төгрөгийн орлого орж ирсэн байна. Энэ дээр Байгаль орчны яам хариулах нь зөв байх аа.

Н.Наранбаатар: Байгаль орчны яамнаас байхгүй. Өөр тэр юутай холбоотой төсөв талаас нь л уг нь асуусан юм л даа. Төсөвт шонхор шувуу барьсны орлого гэж ангийн орлого хэдий хэмжээний юм төвлөрдөг юм гэдэг л асуулт байгаа шүү дээ. Сангийн яамнаас хариулахгүй юу?

Жаргалсайхан гишүүн тодруулъя.

Д.Жаргалсайхан: Сая Монголбанкны захирал орж ирж байсан. Ер нь захирлаар сонгогдсоноос нь, томилогдсоноос нь хойш ерөөсөө анх удаагаа л харж байна л даа. Тэгээд л гараад л алга боллоо. Ингээд Тэргүүн дэд нь байх шиг байна

тиймээ. Тэгэхээр ер нь энэ инфляц ингээд 13 хувьтай ер нь ингээд цаашдаа төсөвт төлж байгаатай холбоотой 18, 19 бараг 20 хувь хүрэх юм шиг байна. Энэ дээр ямар бодлого явуулах гэж байна? Энэ ингээд 20 хувь хүрэх ийм юм руу яг очих уу? Очвол энэ ард иргэд дээр ирж байгаа энэ үнийн өсөлт энэ хүндрэл ямар байдлаар илрэх вэ? Яаж төсөвлөж байна вэ? Энэ дээр нэг хариулт авъя.

Н.Наранбаатар: Монголбанк хариулъя. Ажлын хэсгийн 7 номерын микрофон.

Э.Анар: Гишүүний асуултад хариулъя.

Монголбанк Анар. Төсвийн тодотголтой холбоотой энэ оны эцэс хүртэл бол инфляцын бид нарын дотоод судалгаа, шинжилгээний юмаар энэ 0.5-0.7 нэгж хувь болов уу гэсэн ийм тоо байгаа. Ирэх жилийн төсвийн хувьд бол одоохондоо яг эцэслээгүй байна. Ерөнхийдөө ямархуу байдлаар төсөв батлагдах байхаас хамаарч ирэх жилийн төсөв дээрх инфляц дээр үүсэх дарамт нь ямархуу байх вэ гэдэг нь тухайн үед гарах байх. Яг одоогийн байдлаар тоо мэдээ алга. Бид нарын одоогийн яг төсвийн тодотголтой холбоотойгоор 0.5-0.7 нэгж хувь байлга уу гэсэн ийм төсөөлөлтэй байгаа. Инфляц дээр ирэх дарамт нь ийм байх болов уу гэсэн төсөөлөлтэй байгаа.

Н.Наранбаатар: Ганбаатар гишүүн асуулт асууя.

Г.Ганбаатар: Өдрийн мэнд. 2 асуулт, нэг тодруулга байна.

Нэгдүгээрт нь одоо энэ төсөв төсвийн тодотгол хэлэлцэгдэж байгаа үед энэ дагаж орж ирж байгаа хууль ялангуяа энэ Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль.

Дээрээс нь энэ түүнтэй уялдуулсан энэ тогтоолын төсөл байна л даа Засгийн газарт чиглэл өгөх тухай. Тэнд Улсын Их Хурлаас гарсан энэ Тогтоолын төслийн 5 дээр Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан ЭТТ хаалттай ХК-ийг нээлттэй ХК болгох, үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангах гэж энийг яг юу гэж ойлгож байгаа юм? Энэ ЭТТ-н нөгөө хаалттай хувьцааг 2 дахь зах зээлд борлуулах тэгээд тэр 1072 хувьцаагаа арилжих арилжаалах тухай асуудал юм уу энэ дээр 1 дүгээрт хариулт авъя.

Хоёрдугаарт нь энэ хувийн сургууль улсын сургуулийн энэ сургуулийн хувьсах зардал адилхан байгаа юу? Одоо сошиалаар явж байгаа мэдээ янз бүрийн юм харахлаар чинь янз бүрийн л юм ялгаатай ч юм шиг ойлгогдоод. Нөгөө талдаа тэр нэг гэрт ойр сургууль гээд 50 тэрбум. Үгүй энэ 50 тэрбум төгрөгөөр нэг ийм эндээс батлагдаад явчихвал цаадуул чинь тэгээд та нар Боловсролын яам нь бараг саяын нийгэмд шуугиан тариад байгаа хэлбэрээр бараг хуваах гэж л байсан л байх л даа. Дараа жил яах юм? Ахиад 50 тэрбум, 100 тэрбум болгох юм уу? Нэг хүүхэд энэ жил нэг гэртээ ойрхон сургуульд ингээд орчихлоо гэхэд дараа жил хэрвээ төсөв нь батлагдахгүй бол тэгээд тэр хүүхдийн амьдралаар тоглох юм уу? Энэ чинь ер нь цаашдаа ингэж явах юм уу? 2024 оны төсвийн жишгээр бол дунджаар энэ чинь 10 сургууль, 320 хүүхдийн суудалтай 10 сургууль байх юм байна шүү дээ. Энэ гэрт ойрхон сургууль гээд хөтөлбөр гоё гоё нэртэй юм чинь.

Ер нь Төсвийн Байнгын хорооны гишүүд бид нар уг нь энэ боловсрол, эрүүл мэнд, батлан хамгаалахын зардал дээр нэг их тийм анхаарал тавьдаггүй, задаргааг нь үздэггүй, нийгмийн суурь салбар юм. Эрүүл мэнд, боловсрол Засгийн газар өөрөө өргөн барьж байгаа юм. Батлан хамгаалах бол үндэсний аюулгүй байдалтай холбоотой юм гээд ерөөсөө үзэж хардаггүй байсан чинь одоо сая чинь юу болж байна аа? Тэгээд энэ дээр хариулт аваадахъя.

Н.Наранбаатар: Сая дагасан хуулиудтай холбоотой асуулт асуучихлаа. Энэ дээр хэн хариулах вэ? Сангийн яам хариулах уу? Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт. Дагасан хуулийг ер нь дан дараа нь тусдаа хэлэлцэнэ. Тэгэхдээ одоо энэ дээр мэдээлэл байвал өгчих.

Б.Даваадалай: Үнэт цаасны хуультай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг СЗХ-оос өгөх байх. Чингис хаан баялгийн сангийн хувьд агуулгын хувьд нөгөө 1072 хувьцааг амь оруулах асуудлыг ярьж байгаа. Өнгөрсөн хавар Тавантолгой дээр бид нар олон улсын аудит оруулсан. Хөрөнгийн үнэлгээ хийгдэнэ. Тэгээд хуулийн төсөл дээр гол орж байгаа заалт бол 50-аас дээш хувьцаа эзэмшигчтэй ТӨК-ийг анх зах зээл дээр хувьцаагаа санал болгох шаардлагагүйгээр 2 дахь зах зээл дээр бүртгэлийг нь хийх асуудал ярьж байгаа юм аа. Тэгэхдээ энэ бэлтгэл ажил. Энэ хоорондоо бид нар энэ ондоо багтаагаад үнэлгээ хийх ийм зорилт тавьж байна. Яг хуулийн дэлгэрэнгүй бичилт нарийн юмнуудыг СЗХ-оос дараа нь мэдээлэл өгөх байх аа. Баялгийн сан нэгдлийн хувьд бол Тавантолгой компанийн 1072 хувьцааг арилждаг болох энэ асуудлуудыг үе шаттай хийж байгаа. Сая 6 сард өвлүүлэх асуудлыг шийдсэн. 132 мянган хүний нас барсан хүний хувьцаа өвлүүлэх асуудал шийдэгдсэн. Энэ энэний үр дүнд 66 тэрбум төгрөгийн хуримтлагдсан ноогдол ашиг өвлөж авсан иргэдэд очих боломжтой болж байгаа гэж ойлгож болно. Хэрвээ бид нар энэ бүртгэлийг хийгээд 1072 хувьцаагаа амь оруулчих юм бол арилждаг, өвлүүлдэг, шаардлагатай бол бэлэглэдэг энэ зах зээлийн зарчим руу нь л оруулах гэж байгаа юм гэдгийг гишүүнд хэлье ээ. Тэгээд хуулийн нарийн өөрчлөлттэй холбоотой юмыг СЗХ бэлдсэн учраас дараа нь мэдээлэх байх.

Н.Наранбаатар: СЗХ-оос Байнгын хорооны ажлын албанаас Ганбаатар гишүүнд бичгээр хариулт авч өгөөрэй.

Дараагийн асуултад нь хариулах ёстой. Хувьсах зардалтай холбоотой асуултад хэн хариулах вэ? Сайд орж ирсэн байна. Энх-Амгалан сайд хариулна. Энх-Амгалан сайдын микрофоныг өгье.

Л.Энх-Амгалан: Сая Ганбаатар гишүүний асуултад хариулъя аа.

Энэ жилийн энэ төсвийн 2026 оны төсвийн тодотгол дээр өргөн барьсан гол хөтөлбөрүүдийн нэг гэрт ойрхон сургууль хамгийн сайн сургуулийн төсөл арга хэмжээ нь шаардлагатай байгаа 50 тэрбум төгрөгийн задаргаа 50 тэрбум төгрөг ер нь хэрхэн яаж зарцуулагдах ингэдэг нэлээн ард иргэдийг талцуулсан буруу ташаа мэдээллүүд санаатай санаагүйгээр тараасан нэг ийм нөхцөл байдлууд болж байна л даа. Ганбаатар гишүүн та харж байгаа байх. Гэхдээ нэг зүйл тодорхой байгаа. Юу гэхээр энэ Улсын Их Хуралд өргөн барьсан энэ төсвийн тодотгол дээр ямар нэгэн байдлаар аль нэг хувийн сургуульд мөнгө өгөх тухай асуудал энд ерөөсөө хөндөгдөж тавиагүй гэдгийг та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа болов уу гэж бодож байна.

Хоёр дахь асуудал бол та задаргааг нь яриад байх шиг байна. 50 тэрбум төгрөгөөр нэг 2 тэрбум төгрөг, сургууль 2 тэрбум төгрөг гэж байгаа больсон шүү дээ. Сургууль бол 650 хүүхдийн сургууль бараг үндсэндээ 6-аас 7 тэрбум төгрөг хамгийн багадаа болж байгаа. Энэ бол 7, 8 сургууль барих мөнгөний тухай асуудал яриад байх шиг байна. Тэгэхдээ энэ 50 тэрбумаар чинь бид нар ганцхан ачаалал өндөртэй байгаа сургуулиуд дээр сургаал сургууль түрээслэх тухай асуудал биш Ганбаатар гишүүн ээ. Энэ чинь 4 төрлийн төсөл арга хэмжээ санхүүжүүлэх гэж байгаа ийм мөнгө.

Нэгдүгээрт нь бид нар нэгд өнөөдөр энэ 9 сарын 1-ээс авхуулаад Монгол Улс хөтөлбөрийн шинэчлэл хийж байгаа. 1 дүгээр ангиас авхуулаад. Тийм учраас 18 орчим тэрбум тэрбум төгрөг гэдэг бол Монгол Улсын хэмжээнд хэрэгжиж байгаа 1 дүгээр ангийн хүүхдийн сургалтын орчин, анги танхим, сурах бичгийг сайжруулах чиглэлээр зарагдах мөнгө өө.

Хоёрт нь бол тодорхой төрийн өмчит сургуулиуд өргөтгөлүүд хийгдэнэ. Энэ дээр бас тодорхой өргөтгөлүүд хийгдэнэ. Хамгийн гол асуудал бол өнөөдөр Улаанбаатар хотод газаргүй болчихоод байгаа шүү дээ. Сургууль барья ч гэсэн газаргүй болчихоод байгаа. Тэгэхээр тийм учраас бид нар цаашдаа энэ томоохон баригдаж байгаа энэ хорооллууд дээр улсын комисст заавал ч үгүй сургууль, цэцэрлэгүүдийг нь хүлээж авч байж улсын комисст хүлээж авдаг нэг энэ тогтолцоо руу шилжихгүй бол ингээд л энэ зовлонгоос бид нар хэзээ ч салахгүй юм байна лээ 1 дүгээр асуудал.

Хоёрдугаар асуудал одоо бид нарт шаардлагатай байгаа ойрын хугацаанд шаардлагатай байгаа 108 сургууль, 95 цэцэрлэгийн тооцоо гардаг. Энийг бид нар улсын төсвөөс санхүүжүүлэхийн юм бол бараг ойролцоогоор би андуураагүй бол 2.4 их наядын төсвийн зардлын хөрөнгө оруулалтууд орно. Дахиад энийг ажиллуулахын тулд урсгал зардлууд 300-400 орчим тэрбум төгрөгийн урсгал жил бүхэн тавигдана.

Тийм учраас бид нар 30-40 тэрбум төгрөгөөр жил бүхэн бид нар 40-50 мянган хүүхдийн асуудал шийдэж байгаа Ганбаатар гишүүн ээ. Энэ бол бид төр хувийн хэвшлийн түншлэлээр хийж болж байгаа хамгийн төсвийн татвар төлөгчдийн мөнгийг бол хамгийн үр өгөөжтэй хийж байгаа, хамгийн зөв ажил гэдэг дээр би итгэл үнэмшилтэй байгаа гэдгээ хэлье гэж бодож байна.

Н.Наранбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Ганхуяг гишүүнээр тасаллаа. Ганхуяг гишүүн үг хэлье.

Х.Ганхуяг: Хоёр асуудлыг ярина. 1 дүгээр асуудал Энх-Амгалан сайдтай холбоотой асуудлыг ярина.

Төсвийн Байнгын хорооны дарга байсны хувьд тийм урсгал зардлын задаргаа эксел файл гэж юм байдаггүй юм. Ганбаа гишүүн бараг мэдэж байгаа байх. Манай Жаргалсайхан гишүүн ч мэдэж байгаа. Яагаад гэхээр энэ угаасаа Засгийн газраас өргөн бариад Их Хурлын бүрэн эрхийн асуудал байдаг тэрийг батлахгүй байж болдог, хасаж болдог, тэгэхээрээ бүх л дүнгээр явдаг. Тэгээд тэр нь батлагдчих юм

бол дараад нь батлагдсан дүнгээс хамаараад төсвийн ерөнхийлөн захирагч нар цааш нь задалж баталдаг байх. Уучлаарай тэгвэл би андуурсан байна. Тийм Энх-Амгалан сайдад зориулж хэлж байгаа юм.

Хоёрдугаар асуудал. 2 дугаар асуудал ерөнхийдөө бид нар энэ тодотгол дээр анхаарах зүйл энэ орлого бүрдүүлэлт дээрээ жоохон анхаарах хэрэгтэй. Тийм зардал угаасаа яг хуваариараа гараад л явчих байх. Энэ чинь угаасаа цалин, тэтгэвэр нэмж байгаа болохоор гүйцэтгэлээр нь танах ч байдаг юм уу багасгах ч байдаг юм уу тийм боломж байхгүй юм. Тэгээд тэрнээс яг орлого бүрдүүлэх тал дээр ажилламаар байгаа юм аа. Сая тэгээд тэр Дорнодын асуудлаас болоод гаалиар гарч байгаа Гашуун сухайтаар гарч байгаа машины тоо, нүүрсний тоо бол 3-аас 4 дахин буурсан байна. Тэгээд яг энэ асуудлууд дээрээ цаг алдалгүй арга хэмжээ авч байхгүй бол оны эцэхэд гэхэд энэ татварын орлого, төсвийн орлого чинь тасалдаад эхэлбэл нөхцөл байдал хүндэрнэ шүү дээ.

Энэ дээр яг хариуцаж байгаа Засгийн газрын гишүүд нь онцгой анхаарал хандуулахгүй болохгүй байх гэж бодож байна.

Н.Наранбаатар: Гишүүд үг хэлж дууслаа. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Төсвийн Байнгын хорооны дарга Наранбаатар танилцуулна.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Төсвийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Ажлын хэсэг, гишүүдэд баярлалаа.

13.45 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА